



**"Их эзэн Чингис хаан хөшөө,
Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөө"
цогцолборыг барьж байгуулахад
улсын төсвөөс 2006 онд олгосон
хөрөнгийн гүйцэтгэл**



Зардлын төсөв анх батлагдсанаасаа хоёр дахин өсчээ

Сангийн сайдын хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Улаанбаатар хот 2006 оны 12 дугаар сар

Агуулга

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>ҮАГ-ын нэгдүгээр хэлтэс</p> <p><i>Тэргүүлэх аудитор</i> Д.Ганбилэг</p> <p><i>Ахлах аудитор</i> С.Сэрчхорол</p> <p><i>Аудитор</i> С.Андрюш</p> <p>2006 оны 2 дугаар сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</p> <p>www.mnao.pmis.gov.mn</p> <p><i>Аудитын тайлан, дүгнэлттэй</i> <i>холбоотой асуудлаар нэмж</i> <i>тодруулах, асууж лавлах зүйл</i> <i>байвал 261885 дугаарын утас,</i> <i>323266 дугаарын</i> <i>факсаар харилцана уу.</i></p> <p>ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын 4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6, Улаанбаатар-46</i> <i>Монгол Улс</i></p>	Товчилсон үгсийн жагсаалт	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Бүлэг 1 Барилгын бусад шууд зардал өсч төсөвт өртгийг нэмэгдүүлжээ	
	<ul style="list-style-type: none">Цогцолбор барьж байгуулах шийдвэр гарч, зарим арга хэмжээ авчээ	5
	<ul style="list-style-type: none">Улсын төсвийн санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгосон байна	6
	<ul style="list-style-type: none">Барилгын зураг төсөв олон удаа өөрчлөгдөж, бусад шууд зардал өссөнөөс төсөвт өртөг нэмэгдсэн байна	8
	<ul style="list-style-type: none">Зөвлөмж	10
	Бүлэг 2 Барилга угсралтын ажил анх төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй байна	
	<ul style="list-style-type: none">Барилга угсралтын ажил анх төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй байна.	11
	<ul style="list-style-type: none">Барилгын ажлын нарийвчилсэн төлөвлөгөөг үе шат бүрээр гаргажээ	13
<ul style="list-style-type: none">Гүйцэтгэгчийг шалгуур гаргаж		

Агуулга

	сонгоогүй байна	13
	• Гүйцэтгэгчийн ажилд хяналт тавьж ажиллажээ	13
	• Холбогдох байгууллагын санал, тайлбар	15

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТЗҮААЭГ	Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
БХБТГ	Нийслэлийн Барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газар
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Сангийн сайдын хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Их эзэн Чингис хаан хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг барьж байгуулахад 2006 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн гүйцэтгэлд аудит хийв.

Энэхүү аудитын зорилт нь "Их эзэн Чингис хаан хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг барьж байгуулахад төсвөөс 2006 онд олгосон хөрөнгийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөхөд чиглэгдэв.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Төрийн сангаас захиалагчид болон захиалагч, хэрэгжүүлэгчээс гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн судалгаа, тодруулга авах
- ТЗҮААЭГ-аас НХОГ(БХБТГ)-т олгосон хөрөнгийг холбогдох байгууллага, гүйцэтгэгч зарим байгууллага, аж ахуйн нэгжид шалгах
- Ажлын гүйцэтгэлийн баримт материалтай танилцах, шаардлагатай үед холбогдох бусад байгууллагаас тодруулга авах

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Барилгын бусад шууд зардал өсч төсөвт өртгийг нэмэгдүүлжээ



Танилцуулга

"Цогцолбор" барьж байгуулах шийдвэр гарч, зарим арга хэмжээ авчээ

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар Сүхбаатарын талбай, Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн бунхан, төрийн ордны хойд талын цэцэрлэгийг шинэчлэн засах тухай хэлэлцээд дараахь шийдвэр гаргажээ:

- "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө", "Монгол төрийн тамга" билэгдлийн хөшөө барих, Д.Сүхбаатарын хөшөөг хүрэл болгох, төрийн ордны гадна засал хийх зэрэг ажлыг зохион байгуулах захиалагчийн үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хариуцуулжээ.
- Дээрх ажлыг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг аль болох улсын төсөвт хүндрэл учруулахгүй шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд (хуучин нэрээр), Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт даалгасан байна.
- "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө", "Монгол төрийн тамга" билэгдлийн хөшөөг байгуулахтай холбогдуулан бунханы болон төрийн ордны арын цэцэрлэгт байрлаж байгаа Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Ж.Самбуу нарын шарилыг шилжүүлэн байршуулах

асуудлыг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

- Төрийн ордны барилгыг хүчитгэн бэхжүүлэх, өргөтгөх, засвар, тохижилт хийх асуудлыг судлан боловсруулж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Нийслэлийн хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга нарт даалгасан байна.

1.2 Засгийн газрын хуралдааны 2004 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн тэмдэглэлд "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө, цогцолбор" байгуулах ажлыг 2005 онд эхлүүлж, шаардагдах зардлыг 2005, 2006 оны төсөвт тусгахаар тогтсон байна.

1.3 "Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн их ойг тэмдэглэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Цогцолбор байгуулах болон шарил шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг баталсан.

1.4 "Төрийн ордон, түүний орчныг тохижуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2005 оны 49 дүгээр тогтоолоор Төрийн ордон, түүний орчныг шинэчлэн тохижуулах, "Монгол төрийн тамга" билэгдлийн хөшөө байгуулахтай холбогдуулан төрийн ордны ард Ардын хувьсгалын талбайд байрлах Ж.Самбуугийн шарилыг Алтан-Өлгийд ёслол хүндэтгэлтэйгээр шилжүүлэн, дурсгалын хөшөө босгох ажлыг зохион байгуулахыг Засгийн газарт даалгажээ.

1.5 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2002 оны 221 дүгээр тогтоолоор Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Төрийн харш, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц ..., барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, засвар үйлчилгээ, тавилга, техник, тоног төхөөрөмж, материал, программ хангамжийг тендерт хамруулахгүй байхаар тогтоожээ.

1.6 "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын барилга угсралтын ажилд зориулж 2006 онд 8300,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцсон байна.

Улсын төсвийн санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгосон байна


1.7 Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга асан С.Баярцогт, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ч. Хүрэлбаатар нарын баталсан цогцолборын зураг төсөл, барилга угсралт, уран баримлын ажлын график, санхүүжилтийн хуваарийн дагуу 2006 онд 5500,0 сая төгрөг санхүүжигдэхээр төлөвлөгдсөн боловч улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтын 2006 оны тодотгосон

төлөвлөгөөгөөр барилга угсралтын ажилд 6800,0 сая, барималд 1500,0 сая, бүгд 8300,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.


1.8 Улсын төсвөөс барилга угсралт, баримлын ажилд зориулан 2006 оны 2 дугаар сард 250,0 сая, 3 дугаар сард 1194,0 сая, 4 дүгээр сард 1077,0 сая, 5 дугаар сард 979,0 сая, 6 дугаар сард 1956,2 сая, 7 дугаар сард 860,0 сая, 8 дугаар сард 415,8 сая, 10 дугаар сард 1289,1 сая, 11 дүгээр сард 278,9, бүгд 8300,0 сая төгрөг олгожээ.

1.9 Дээрх байдлаас үзэхэд батлагдсан хөрөнгийг зохих хуваарийн дагуу санхүүжүүлж энэ оны хувьд жигд төвлөрчээ. Үүнийг диаграммаар харуулбал:

Улсын төсвөөс олгосон санхүүжилт



1.10 Захиалагч ТЗҮААЭГ-аас хэрэгжүүлэгч НХОГ-т зураг төсөл, барилга угсралт, барималд зориулж 3425,6 сая, "Нийслэл Өргөө" ХК-д 4057,2 сая, барималч Л.Болдод 394,0 сая, "Авзага трейд" ХХК-д 17,8 сая, УГЕГ-т 84,1 сая, Дарханы төмөрлөгийн үйлдвэрт 216,0 сая, Захиалагчийн товчоонд 20,0 сая, бүгд 8214,7 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Үүнийг диаграммаар харуулбал:



1.11 НХОГ (одоо БХБТГ болон өөрчлөгдсөн)-т олгосон 3425,6 сая төгрөгөөс 250,0 сая төгрөгийг барималд, үлдсэн 3175,6 сая төгрөгийг "Нийслэл-Өргөө" ХК-д барилга угсралтын ажилд зориулан дамжуулан олгосон байна.

1.12 Захиалагчаас гүйцэтгэгч "Нийслэл-Өргөө" ХК-д 4057,2 сая төгрөг олгосноос 500,0 сая төгрөгийг баримлын гадаад материалд олгосон байна.

1.13 Уран барималд зориулан барималч Л.Болдод 2005-2006 онд 1344,0 сая төгрөг олгосноос хүрэл цутгуурт 853,5 сая, чулуун хийцэд 29,7 сая, материалд 202,2 сая, томилотод 37,7 сая, тээвэрт 37,1 сая, цахилгаанд 11,5 сая, түрээст 2,1 сая, уран бүтээлийн шагнал, ажлын хөлсөнд 170,2 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Захиалагч, хэрэгжүүлэгч байгууллагууд гүйцэтгэгчдэд санхүүжилтийг бүрэн олгосон байна

1.14 Захиалагч энэ онд батлагдсан 8300,0 сая төгрөгөөс 8214,7 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож одоо 85,3 сая төгрөг үлдсэн бөгөөд урд оны 253,3 сая төгрөгийн үлдэгдлийг оролцуулбал бүгд 320,6 сая төгрөг харилцах дансанд үлдсэн байна.

1.15 Энэ нь гүйцэтгэгчээс зураг төсөл, уран баримал, барилгын ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь бүрэн гаргаж ирүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Захиалагч гэрээнд тусгагдаагүй байгууллагад хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчээр дамжуулалгүй санхүүжилт олгожээ

1.16 Гүйцэтгэгч "Нийслэл-Өргөө" ХК-ий хүсэлтээр захиалагч тус компаний дансаар дамжуулалгүй Дарханы төмөрлөгийн үйлдвэрт 216,0 сая, УГЕГ-т 84,1 сая, "Авзага трейд" ХХК-д бүгд 17,8 сая, бүгд 317,9 сая төгрөг шилжүүлжээ.

1.17 2006 онд цогцолборын барилга угсралт, барималд зориулан 8214,7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос гүйцэтгэгчээс 9145,0 сая төгрөгийн барилга угсралт болон баримал, зургийн ажил хийснээр тооцож ирүүлснийг захиалагч 8966,6 сая төгрөгөөр хянасан нь нийт гүйцэтгэлийн 98,1 хувийг эзэлж байна.

1.18 Гүйцэтгэгч "Нийслэл-Өргөө" ХК барилга угсралтын ажлын гүйцэтгэлд тооцогдохгүй 4,3 сая төгрөгийн багаж хэрэгсэл, ажлын хувцас, материалыг зардалд оруулж тооцсон байлаа.

Барилгын зураг, төсөв олон удаа өөрчлөгдөж, бусад шууд зардал өсч төсөвт өртгийг нэмэгдүүлжээ

1.19 Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга асан С.Баярцогт, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар нарын баталсан "Их эзэн Чингис хааны хөшөө, төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын зураг төсөл, барилга угсралт, уран баримлын ажлын график, санхүүжилтийн хуваарийн дагуу нийт

төсөвт өртгийг 7500,0 сая төгрөгөөр баталж, уг барилгыг 2005-2006 онд барьж дуусгахаар төлөвлөсөн байна.

1.20 2004 онд хийсэн "Их эзэн Чингис хааны хөшөө, төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын эскиз зургийн дагуу гүйцэтгэх барилга угсралтын ажлын объём хэмжээг бүрэн гүйцэд тооцох боломжгүйгээс "Цэц манлай" ХХК барилгын төсөвт өртгийн урьдчилсан тооцоог 8891,7 сая төгрөгөөр 2005 оны 6 дугаар сарын 20-нд хийжээ.

1.21 Барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тооцсоны дараа 2005 оны 6 дугаар сарын 28-нд Барилга, хот байгуулалтын сайдын "Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай" 50 дугаар тушаал гарч барилгын ажилчдын цалинг 80,0 хувь өсгөсөн бөгөөд улмаар Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 200 дугаар тушаалаар батласан "Барилгын төсөв зохиох заавар"-ын дагуу бусад шууд зардал 58,4 хувь (үүнд: түр барилгын, өвлийн нэмэгдлийн, хог цэвэрлэгээний, шагнал урамшил), нэмэгдэл зардал 57,0 хувь, төлөвлөгөөт хуримтлал 95,0 хувиар шууд өссөнөөс барилгын нийт төсөвт өртөг 1557,1 сая төгрөгөөр нэмэгджээ.

1.22 Мөн барилгын архитектурын нарийн гоёл чимэглэл, дээврийн өнгөт шилэн куполууд, фанер болон дотор халаалт, салхивч, цэвэр, бохир усны хангамж, цахилгаан гэрэл, холбоо дохиоллын систем, гадна дулаан, цахилгаан хангамжийн дэд өртөө зэрэг инженерийн шугам сүлжээний ажлууд эскиз зурагт огт төлөвлөгдөөгүй байсан бөгөөд гаднаас гэрээгээр нийлүүлэгдэх бараа материал, тоног төхөөрөмж, (лифт, рентген аппарат) ордны хамгаалалтын тусгай хийцийн төмөр хашаа, шалган нэвтрүүлэх 2 ширхэг байр, төрийн тамганы хөшөө босгох ажлууд анхны эскиз зурагт тусгагдаагүй байсныг нэмж тооцсоноор төсөвт өртөг 17473,3 сая төгрөг болжээ.

1.23 2006 оны 6 дугаар сарын 23-нд улсын экспертизээр дээрх төсвийг баталсан бөгөөд анхны батласан төсвөөс 2 дахин өсчээ.

1.24 Барилга угсралтын ажлын зураг өөрчлөгдсөнөөс шалтгаалж батлагдсан дээрх төсөвт өртгийг 38,5 сая төгрөгөөр бууруулж 17434,8 сая төгрөг болгон 2006 оны 11 дүгээр сарын 10-нд өөрчилжээ.

1.25 2006 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар батлагдсан төсвөөс 10300,0 сая төгрөг буюу 58,9 хувийг зарцуулжээ.

1.26 Гадаадаас бэлтгэх барилгын материал, тоног төхөөрөмжийн захиалгыг гүйцэтгэгч бэлтгэж байгаа нөхцөлд захиалагчийн зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.27 Батлагдсан төсөвт өртөгт бунхант индэр буулгахад зориулсан зардал тусгагдсан боловч харин шарил шилжүүлэн байршуулах зардал 368,5 сая төгрөг тусгагдаагүй, барилга угсралтын ажилд олгосон санхүүжилтээс зарцуулагдсан байна.

1.28 Улсын экспертизээр батлагдсан төсөвт "зээгт наамал" худалдан авч музейд байршуулах 450,0 сая төгрөг тусгагдсаныг барилга угсралтын ажлын төсөвт өртгөөс хасч тооцох нь зүйтэй.

1.29 2005, 2006 онд барималч Л.Болдод уран баримлын ажлын хөлс болон шагнал урамшилд олгосон 170,2 сая төгрөгөөс 17,0 сая төгрөг, барилга захиалагчийн товчооноос барилгачдын шагналд олгосон 1,3 сая төгрөгөөс 130,0 мянган төгрөгийн хүн амын орлогын албан татвар тооцоогүй байсан бүгд 17,2 сая төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Зөвлөмж :

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Батболдод:

- "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын барилга угсралтын ажлын төсөвт "зээгт наамал худалдан авах"-аар тусгасан зардлыг төсөвт өртгөөс хасах;
- 2007 онд гадаадаас бэлтгэх барилгын материал, тоног төхөөрөмжийн захиалгыг хянах

Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралтад:

- Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 онд баталсан "Барилгын төсөв зохиох заавар"-ыг хянаж шинэчлэх.

Бүлэг 2

Барилга угсралтын ажил анх төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй байна

Танилцуулга

2.1 ЗГХЭГ-ын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар 2005 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Цогцолборыг барьж байгуулахтай холбогдсон зураг төсөл боловсруулах даалгаврыг баталжээ.

2.2 Гэхдээ хөшөө, баримал, цогцолборын барилгын захиалагчаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ТЗҮААЭГ/, хэрэгжүүлэгчээр НХОГ (одоо Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газар) гэж заасан боловч зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, ажлын гүйцэтгэлийг тооцох зэрэг захиалагчийн гол үүргийг хэрэгжүүлэгчид, харин гүйцэтгэлийн санхүүжилт хийх, газар, техникийн нөхцөлүүдэд зөвшөөрөл гаргуулах зэрэг асуудлыг захиалагчдад хариуцуулсан нь оновчтой бус болжээ.

2.3 НХОГ (одоо БХБТГ) зураг төсөл боловсруулах 5 байгууллага, барилга угсралтын ажил гүйцэтгэх "Ган харш", "Нийслэл Өргөө", "Вертикаль", "Мандах трейд" ХХК, хөшөө, баримал хийх МУЭХ-ны дарга Л.Болд, тэдгээрийн хоорондын ажлыг уялдуулан зохицуулах инженер нарыг сонгон авч гэрээ байгуулжээ.

2.4 Цогцолборын техникийн зураг төсөл, эскиз-ийг Засгийн газрын хуралдаанаар удаа дараа хэлэлцэж, улмаар уг ажлыг эхлүүлэх, санхүүжилтийг 2005, 2006 оны төсөвт тусган хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь хурлын тэмдэглэлд тусгагдсан байна.

2.5 Цогцолбор нь баганат галерей-музей, ёслол хүндэтгэлийн өргөө, хөшөө баримал гэсэн үндсэн 3 хэсгээс бүрджээ.

Цогцолборын эхний ээлжинд төлөвлөсөн ажил хугацаандаа хийгджээ

2.6 Төрийн ордны өмнө талд барилгын талбайн зохион байгуулалт хийгдэж, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Ж.Самбуу нарын шарилыг Алтан-Өлгийд шилжүүлэн байршуулахтай холбоотой эхний ажил хийгдсэн бөгөөд Алтан-Өлгийд шинээр хашаа, бунхан барих, орчныг сэргээн тохижуулах, хотын төвөөс очих замыг хатуу хучилттай болгох ажил бүрэн хийгдэж дуусчээ.

Барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөөг үе шат бүрээр гаргажээ

2.7 "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын барилга угсралтын ажлыг 3 үндсэн объектоор төлөвлөж, шилэн галерей, хүндэтгэлийн өргөө, хөшөө баримал, инженерийн шугам сүлжээний гадна

холболт тус бүрээр нарийвчлан төлөвлөсний дагуу барилга угсралт, баримлын ажил явагдаж байна.

2.8 "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын барилга угсралтын ажлаас Ардын хувьсгалын 85 жил, Их эзэн Чингис хааны 800 жилийн ойгоор "Хаадын болон морьт баатруудын хөшөө"-ний нээлтийг хийжээ.



ХУБИЛАЙ ХААН

ЧИНГИС ХААН

ӨГӨДЭЙ ХААН

2.9 Монгол улс тунхагласаны 82 жилийн ойгоор "Цогцолборын баганат шилэн галерей", "Монгол төрийн тамганы хөшөө"-г тус тус ашиглалтад өгчээ.



2.10 Одоо төрийн түүхийн музей доторхи дулаалга, инженерийн шугам сүлжээг угсрах ажил, ёслол хүндэтгэлийн өргөөний хэсэгт зоорийн болон 1-5 давхрын багана, дам нуруу, хучилтыг цутгаж дуусгаад өрлөгийн ажилдаа ороод байна.

2.11 Ирэх онд түүхийн музейн хэсэгт шавардлага, засал, халаалт, салхивч, цахилгаан, холбоо, галын дохиоллын ажлыг дуусгах, ёслол хүндэтгэлийн

өргөөний дотоод засал чимэглэл, интернет, лифт, сантехник, цахилгааны ажил, тавилга, тоног төхөөрөмжийг угсран, зүүн, баруун жигүүрийг барьж Ардын хувьсгалын 86 жилийн ойн өмнө уг барилгыг бүрэн ашиглалтад өгөхөөр ажиллаж байна.

Гүйцэтгэгчийг шалгуур гаргаж сонгоогүй байна

2.12 "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын барилга угсралт болон зураг, төсөл, баримлын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг НХОГ (одоо БХБТГ), барилга угсралтын ажлыг "Нийслэл -Өргөө ХК, төсвийг "Цэц манлай" ХХК, зургийг "Архитектур" нэгдлээр хийлгүүлжээ.

2.13 Захиалагч, хэрэгжүүлэгчийн ажил давхардсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа захиалагчийг оролцуулаагүй, захиалагчийн шийдвэргүй гүйцэтгэгчийг сольсон зэргээс барилгын ажил хойшлогджээ.

Барилга угсралтын ажил анх төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй байна

2.14 НХОГ-ын (одоо БХБТГ) сонгосон зураг төслийн "Архитектур" нэгдэлтэй ТЗҮААЭГ гэрээ байгуулж, уг зураг төсөл 2005 оны 8 дугаар сарын 20-нд дуусах байсан боловч об'ём хэмжээг нэмэх, хасах талаар зарим санал, чиглэл гарч эскиз төлөвлөгөөг баталж зөвшөөрөлцөх гэсээр байгаад хугацаа алдаж 2006 оны 2 дугаар сарын 15-нд дуусахаар 6 сараар хойшлогдсон боловч 6 дугаар сарын 20-нд эцэслэн хийжээ.

2.15 Барилгын зураг төслийг олон удаа өөрчилж эцэслэн шийдээгүй, зураг төсөл, барилга угсралтын ажил зэрэг явагдаж байгаагаас барилга угсралтын ажил графикт хугацаандаа хийгдээгүй байна.

2.16 2006 онд уг барилга угсралтын ажил дуусах байсан боловч дээрх шалтгаанаас болж барилга угсралтын ажил 58,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.17 "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын барилгын зургийн ажил эцэслэн хийгдсэн боловч ажлын явцад өөрчлөгдөх хандлагатай байна.

Гүйцэтгэгчийн ажилд хяналт тавьж ажиллажээ

2.18 Гүйцэтгэгчийн ажилд захиалагчийн зүгээс хяналт тавьж ажиллажээ. Үүнд: ТЗҮААЭГ-ын дэргэд барилга захиалагчийн товчоо ажиллаж байгаа бөгөөд энэ онд ЗГХЭГ-ын даргын тушаалаар "Цогцолборын барилгыг ашиглалтад оруулах захиргаа" байгуулсан байна.

2.19 Энэ захиргаа барилгын үйлдвэрлэлийн явц байдалд нийцүүлэн гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулж, ажлын дараалал тогтоох, шаардлагатай хүн хүч, материал техникийн хангамж, хуваарилалтыг зохицуулах үүрэгтэй ажиллаж байна.

2.20 Тус захиргаанаас талбайд 2 инженер, товчооны зүгээс холбогдох мэргэжлийн 3 инженер барилга, сантехник, цахилгаан, холбоо дохиолол, архитектор, дулаан, төсөв санхүүгийн гэсэн чиглэлээр хяналт тавьж байгаагийн зэрэгцээ УМХГ болон хэрэгжүүлэгч Нийслэлийн БХБТГ –аас хяналт тавьж ажиллаж иржээ.

ЗӨВЛӨМЖ: 2

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Батболдод:

- Барилга угсралтын ажлыг батлагдсан төсөв, графикт хугацаанд нь багтаан ашиглалтад оруулах ;